



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/003/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 7033-3019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.13 № 153

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд батлагдсан бизнес төлөвлөгөөний орлогыг 98,079.0 мянган төгрөгөөр тасалж, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй;
2. Гэрээний дагуу төлөх 38,841.2 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй;
3. Олон төрлийн үйл ажиллагааг нэг дор төвлөрүүлэн хэт нүсэр үйл ажиллагааны чиглэлийг бий болгосон.
4. Бүтэц зохион байгуулалтыг оновчтой үр ашигтай байдлаар зохион байгуулаагүй
5. Газар тариалангийн техник тоног төхөөрөмжийг дамжуулан түрээслэх үйл ажиллагаа нь хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлд тусгагдаагүй

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчлүүд нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь дангаараа болон нийт дүнгээрээ өргөн тархаагүй гэж үзсэн тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ-ын дүрэм”-ын 7 дугаар зүйлийн 7.8.1, 7.8.3, 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түр ашиглуулах 01 дугаартай гэрээний холбогдох заалтуудыг зөрчсөн аудитын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	42,066,181.74
8	Бараа материал	-	56,413,291.50
12	Мал амьтад	-	152,263,932.00
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	250,743,405.24
15	Үндсэн хөрөнгө барилга	-	1,607,422,614.32
16	Биологийн хөрөнгө	-	985,862,048.00
22	Биет бус хөрөнгө	-	143,568,500.00
23	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	1,750,991,114.32
24	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	-	<b>2,987,596,567.56</b>
30	Татварын өр	-	487,664.79
37	Бусад богино хугацаат өр төлбөр	-	38,841,200.00
39	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	39,328,864.79
46	Өр төлбөрийн нийт дүн	-	39,328,864.79
47	Эздийн өмч	-	1,087,901,341.75
48	Өмч: а) төрийн	-	1,087,901,341.75
49	б) хувийн	-	-
50	в) хувьцаат	-	-
56	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-	1,860,366,361.02
57	Эздийн өмчийн дүн	-	2,948,267,702.77
58	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	-	<b>2,987,596,567.56</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого ( цэвэр )	-	151,525,000.00
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг	-	151,525,000.00
4	Түрээсийн орлого	-	53,866,000.00
8	Бусад орлого	-	2,053,245,433.50
	Нийт орлогын дүн		2,258,636,433.50
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	398,270,072.48
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	1,860,366,361.02
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татвар дараах ашиг (алдагдал)	-	1,860,366,361.02
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	1,860,366,361.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2	Мөнгөн орлогын дүн (+)	-	304,991,200.00
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	304,991,200.00
7	Татаас санхүүжилтийн орлого	-	99,600,200.00
8	Бусад мөнгөн орлого	-	205,391,000.00
9	Мөнгөн зарлагын дүн (-)	-	262,925,018.26
10	Ажиллагчдад төлсөн	-	115,193,317.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	23,950,338.98
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	-	111,418,851.28
16	Татварын байгууллагад төлсөн	-	12,362,511.00
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	42,066,181.74
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	42,066,181.74
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	42,066,181.74

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
2	Өмчид гарсан өөрчлөлт	1,087,901,341.75	-	1,087,901,341.75
3	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	1,860,366,361.02	1,860,366,361.02
4	Зарласан ногдол ашиг	-	-	-
5	2025 оны 12- р сарын 31-ний үлдэгдэл	1,087,901,341.75	1,860,366,361.02	2,948,267,702.77

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Санхүүгийн тайлангийн аудитаар 303,768.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> 2 алдаа илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.** Үүнд:

- Хангамжийн материал дансанд 738 тооны 152,263.9 мянган төгрөгийн өртөг бүхий мал амьтдыг бүртгэснийг эргэлтийн сүргийн мал амьтад дансанд бүртгүүлэн залруулав.
- Орлогын тайлангийн бусад орлогод хэсэгт 151,505.0 мянган төгрөгийн борлуулалтын орлого давхардан илүү татагдаж, тайлагнагдсаныг аудитын явцад залрууллаа.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.2, 5 дугаар зүйлийн 5.1.4, 13.1 дэх заалтууд болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, ангилал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Аудитаар залруулагдаагүй нийт 136,920.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч, 38,841.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 98,079.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.**

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар илэрсэн 136,920.2 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдал 7,244.9 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1. Тус хуулийн этгээд нь аймгийн ХХААГ-тай "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түр ашиглуулах гэрээ"-г байгуулан тайлант онд 38,841.2 мянган төгрөгийн түрээсийн төлбөр өгөхөөр харилцан тохиролцон ажиллаж, ХХААГ-ын дансанд бүртгэлтэй хөдөө аж ахуй, газар тариалангийн зориулалт бүхий тоног төхөөрөмжүүдийг түрээслүүлэн тайлант хугацаанд нийт 53,866.0 мянган төгрөгийн түрээсийн орлого бүрдүүлсэн боловч, тайлант онд түрээсийн төлбөрийг ХХААГ-т төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд 38,841.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, гэрээний үүргээ хангаж ажиллаагүй, ХХААГ-аас гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дүгнэж, төлбөрийг 2026 онд төлөхөөр хугацааг хойшлуулсан актыг үйлдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түр ашиглуулах 01 дугаартай гэрээний холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: ХХААГ-ын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.*

### 3.2 Албан шаардлага

3.2.1. Тус хуулийн этгээд нь 2025 оны 2 дугаар сараас үйл ажиллагаагаа эхлүүлэн бизнес төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж ажилласан бөгөөд тус төлөвлөгөөнд хүүхдийн тамир зуслангийн үйл ажиллагаанаас 203,000.0 мянган төгрөг, ахмадын амралтын үйл ажиллагаанаас 59,400.0 мянган төгрөг, ХАА-ын тоног төхөөрөмжийн түрээсийн орлогоос 41,050.0 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогоор 303,450.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталснаас хүүхдийн тамир зуслангийн орлогоор 151,505.0 мянган төгрөг, ХАА-ын тоног төхөөрөмжийн түрээсийн орлогоор 53,866.0 мянган төгрөг, нийт 205,371.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, орлогын төлөвлөгөөг 67.7 хувиар биелүүлж, орлогыг 98,079.0 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**", Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ны 18 дугаар тогтоолоор баталсан "Тунгалаг тамир цогцолбор" ОНӨААТҮГ-ын дүрэм"-ын 7 дугаар зүйл үйлдвэрийн газрын удирдлагын эрх, үүргийн 7.8.1-д "Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, **хэрэгжилтийг хангаж ажиллана**", 7.8.3-д "Үйлдвэрийн газрын эрх ашгийг дээдэлж,... байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, **зорилтот түвшнийг биелүүлэх**,... " гэсэн заалтуудтай нийцэхгүй байна гэсэн заалтуудтай нийцэхгүй байна

*Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.*

3.2.2. Тус хуулийн этгээд нь СИ-ТИ-ЭС ХХК-ний ААН-ийн санхүүгийн программын ашиглан НББ-ийн үйл ажиллагааг явуулсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж, ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### **3.3 Зөвлөмж**

Хуулийн этгээдийн тайлангийн жилд явуулсан дээрх үйл ажиллагаа болон бүтэц зохион байгуулалтыг авч үзэхэд хөрөнгийн төвлөрлийг нэг дор хэт нүсэр бий болгосон, хүүхдийн зуслан, ахмадын амралтын үйл ажиллагаа нь байнгын тогтвортой ажиллах мэргэжлийн боловсон хүчнээр хангагдаагүй, бүтэц зохион байгуулалтын хувьд нэгдмэл ашиг сонирхолтой байж болзошгүй нөхцөл байдал үүссэн байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

- Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААТҮГ- ын улсын бүртгэлд бүртгээгдсэн үйл ажиллагааны чиглэлийг дахин нягталж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой, цомхон үр ашигтай байдлаар зохион байгуулах,
- ХАА-н техник тоног төхөөрөмжийг дахин түрээсэлж байгаа үйл ажиллагааг таслан зогсож, холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх
- Тамир зуслан болон ахмадын амралтын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, стандартыг мөрдөж, үйл ажиллагаанаас гарах үр дагавраас урьдчилан сэргийлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

.....оОо.....

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хангамжийн материал дансанд мал амьтдыг бүртгэсэн	1	152,263.9			1	152,263.9	1	152,263.9				
Орлогыг давхардуулж бүртгэсэн	1	151505.0			1	151505.0	1	151505.0				
Нийт дүн	2	303,768.9			2	303,768.9	2	303,768.9				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй	1	98,079.0			1	98,079.0						
Өр төлбөрийг барагдуулаагүй	1	38,841.2	1	38,841.2								
НББ-ийн бодлогын баримт бичиггүй	1	0			1	0						
Бүтэц зохион байгуулалт оновчгүй	1	0					1	0				
Нийт дүн	5	136,960.2	1	38,841.2	2	98,079.0	1	0				